**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ГСА-2026/028/-НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Говьсүмбэр аймаг<br>2026 он | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга ,<br>тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн:<br>Миндүг аудит ХХК-ийн захирал: Б.Бүзмаа<br>Утас: 91160110 Цахим хаяг: buzmaa@mindug.mn<br>Аудитын менежер: Ц.Уянга<br>Утас: 86034911 Цахим хаяг: info@mindug.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 6
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 11
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| АИТХ | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| АЗДТГ | Аймгийн засаг даргын тамгын газар |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| ГСАТАГ | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НА | Нийцлийн аудит |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2026.03.03 № 48

танай __________ -ны № __________ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ТӨВИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Ч.ОТГОНСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны заасны дагуу Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 49.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Тусгай зориулалтын 54 нэр төрлийн 43.5 сая төгрөгийн бараа материалыг шаардах хуудас, зарлагын баримтгүй, бараа материалыг бодит гүйцэтгэлээр нь хянаж, нотлох баримтад үндэслэн тухай бүр тайлант хугацаанд зарлагадаагүй, байгууллагын даргын тушаалаар шууд данснаас хассан.
2. Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 29.6 сая төгрөгийн УАЗ фургон автомашин нь жолоочийн буруутай үйлдлээс болж эвдэрсэн ба даатгалын байгууллагаас тогтоосон 18.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүй, автомашиныг одоог хүртэл хэвийн байдалд оруулаагүй, өмч хөрөнгийн ашиглалтын байдалд удирдлагаас

4226050215

хэрэгжүүлэх хяналт сул, нягтлан бодох бүртгэлээр хяналт тавьж ажиллаагүй, тооллогын комисс тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй

3. Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй УАЗ фургон автомашин нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж эвдрэл үүсэж, 2023 оны 09 дүгээр сараас хойш ашиглагдаагүй байхад 5.6 сая төгрөгийн элэгдэл тооцож хөрөнгийг үнэгүйдүүлсэн, тайланд залруулга хийгээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.4, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.5, 72 дугаар зүйлийн 72.4.3, 72.4.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 129 дугаар зүйлийн 129.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн ба зохистой байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **188,837,360.27** | **228,915,212.28** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 8,820,000.00 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 8,820,000.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 8,820,000.00 | - |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 8,820,000.00 | - |
| **33** | **АВЛАГА** | - | 41,113,628.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 40,785,650.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 327,978.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 327,978.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 180,017,360.27 | 187,801,584.28 |
| **351** | **Түүхий эд материал** | 146,321,878.10 | 131,854,596.11 |
| 35130 | Эм боох материал | 146,321,878.10 | 131,854,596.11 |
| **354** | **Хангамжийн материал** | 33,695,482.17 | 55,946,988.17 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,824,330.00 | 1,429,220.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,517,900.00 | 23,507,356.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 922,000.00 | 1,402,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 25,431,252.17 | 29,608,412.17 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **228,897,234.77** | **206,785,287.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 228,897,234.77 | 206,785,287.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 161,697,234.77 | 139,585,287.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 14,350,400.00 | 14,350,400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (4,067,391.18) | (4,784,911.14) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 126,359,428.15 | 126,359,428.15 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (117,388,858.22) | (126,029,329.35) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 226,748,101.70 | 213,358,601.94 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (86,122,446.82) | (84,925,250.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,437,813.17 | 14,773,406.59 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,619,812.03) | (13,517,058.04) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 67,200,000.00 | 67,200,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,430,000.00 | 2,430,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,430,000.00) | (2,430,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 67,200,000.00 | 67,200,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **417,734,595.04** | **435,400,500.25** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **97,628,418.80** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 97,628,418.80 |
| **413** | **Өглөг** | - | 97,628,418.80 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 150,443.80 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 10,746,825.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 86,731,150.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 86,731,150.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **417,734,595.04** | **338,072,081.45** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 417,734,595.04 | 338,072,081.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 67,200,000.00 | 67,200,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 67,200,000.00 | 67,200,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 348,304,905.23 | 268,642,391.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 317,474,110.93 | 348,304,905.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 30,830,794.30 | (79,662,513.59) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,229,689.81 | 2,229,689.81 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **417,734,595.04** | **435,700,500.25** |

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Данс-ны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,225,451,299.69** | **1,123,690,927.16** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **314,058,529.30** | **223,610,886.59** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 314,058,529.30 | 223,610,886.59 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,520,200.00 | 4,387,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,020,200.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,500,000.00 | 4,387,200.00 |
| 120009 | Бусад орлого | 653,688.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 117,830,999.12 | 25,240,906.59 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 183,053,642.18 | 193,982,780.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **911,392,770.39** | **904,653,864.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 769,450,500.00 | 773,604,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 769,450,500.00 | 773,604,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 141,942,270.39 | 131,049,064.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,228,752.69 | 58,107,864.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,713,517.70 | 72,941,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,194,620,505.39** | **1,201,803,440.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,194,620,505.39** | **1,201,803,440.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 961,293,632.04 | 1,066,471,182.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 411,845,147.18 | 529,037,501.88 |
| 210101 | Үндсэн цалин | 246,464,246.50 | 290,240,132.88 |
| 210102 | Нэмэгдэл | 119,439,167.68 | 163,153,849.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,925,633.00 | 49,305,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,016,100.00 | 26,338,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,676,825.71 | 63,483,185.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,441,162.96 | 42,561,653.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,847,574.82 | 5,444,520.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,043,731.72 | 4,162,444.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,367,291.57 | 2,365,776.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,977,064.64 | 8,948,789.83 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,419,765.95 | 34,034,159.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 687,400.00 | 1,236,865.62 |
| 210302 | Түлш, халаалт | 7,664,400.00 | 10,062,033.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 567,065.95 | 1,735,260.37 |
| 210304 | Байрны түрээс | 17,500,900.00 | 21,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,375,124.00 | 30,697,974.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,851,250.00 | 4,422,940.10 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,048,007.00 | 5,852,592.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,266,267.00 | 1,405,386.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 110,000.00 | 130,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,099,600.00 | 9,959,200.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | - | 8,927,856.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 264,366,295.27 | 177,963,663.89 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 264,366,295.27 | 177,963,663.89 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,814,950.00 | 1,394,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 509,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 12,305,950.00 | 1,394,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 21,624,500.00 | 10,790,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,624,500.00 | 10,790,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 116,422,779.00 | 134,841,485.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,653,239.00 | 126,336,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 326,400.00 | 384,130.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 313,740.00 | 197,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 78,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,860,000.00 | 6,645,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 134,400.00 | 48,155.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,748,244.93 | 84,228,313.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,480,000.00 | 36,755,460.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 120,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 42,268,244.93 | 47,352,853.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 233,326,873.35 | 135,332,258.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,810,809.00 | 19,194,843.80 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,360,809.00 | 15,515,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,450,000.00 | 3,679,343.80 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 198,516,064.35 | 120,711,237.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 198,516,064.35 | 116,137,414.48 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,573,823.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **30,830,794.30** | **(78,112,513.59)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 1,550,000.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | - | 1,550,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (1,550,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **30,830,794.30** | **(79,662,513.59)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **924,566,658.39** | **909,441,064.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,173,888.00** | **4,787,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,173,888.00 | 4,787,200.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12,520,200.00 | 4,787,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,020,200.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,500,000.00 | 4,787,200.00 |
| 120009 | Бусад орлого | 653,688.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **911,392,770.39** | **904,653,864.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 769,450,500.00 | 773,604,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 769,450,500.00 | 773,604,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 141,942,270.39 | 131,049,064.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,228,752.69 | 58,107,864.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,713,517.70 | 72,941,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **897,835,658.39** | **918,261,064.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **897,835,658.39** | **918,261,064.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **664,508,785.04** | **776,498,226.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 411,064,730.30 | 529,765,480.88 |
| 210101 | Үндсэн цалин | 245,683,829.62 | 291,531,100.88 |
| 210102 | Нэмэгдэл | 119,439,167.68 | 162,929,911.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,925,633.00 | 48,965,949.00 |
| 210104 | Урамшуулал | 23,016,100.00 | 26,338,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,039,056.59 | 63,483,184.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,803,393.84 | 44,034,069.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,847,574.82 | 4,791,191.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,043,731.72 | 3,604,765.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,367,291.57 | 2,570,044.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,977,064.64 | 8,483,112.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,419,765.95 | 34,034,159.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 687,400.00 | 1,236,865.62 |
| 210302 | Түлш, халаалт | 7,664,400.00 | 10,062,033.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 567,065.95 | 1,735,260.37 |
| 210304 | Байрны түрээс | 17,500,900.00 | 21,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,160,104.00 | 10,188,261.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,697,500.00 | 2,020,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,965,737.00 | 4,458,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,266,267.00 | 1,104,811.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 110,000.00 | 110,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,120,600.00 | 2,494,750.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 10,482,899.20 | 6,253,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,482,899.20 | 6,253,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,814,950.00 | 24,826,556.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 509,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 12,352,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,305,950.00 | 12,474,156.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 21,624,500.00 | 9,940,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 21,624,500.00 | 9,940,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 116,422,779.00 | 90,686,785.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,653,239.00 | 83,286,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 326,400.00 | 384,130.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 313,740.00 | 87,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 78,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,860,000.00 | 6,802,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 134,400.00 | 48,155.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,480,000.00 | 7,320,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,480,000.00 | 7,200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 120,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **233,326,873.35** | **141,762,837.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,810,809.00 | 17,544,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,360,809.00 | 15,515,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,450,000.00 | 2,028,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 198,516,064.35 | 124,218,437.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 198,516,064.35 | 119,644,614.48 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,573,823.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **26,731,000.00** | **(8,820,000.00)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **26,211,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **26,211,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 26,211,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26,211,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(26,211,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 520,000.00 | (8,820,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 8,300,000.00 | 8,820,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 8,820,000.00 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 317,474,110.93 | 386,903,800.74 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 317,474,110.93 | 386,903,800.74 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 30,830,794.30 | 30,830,794.30 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 348,304,905.23 | 417,734,595.04 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 348,304,905.23 | 417,734,595.04 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 348,304,905.23 | 417,734,595.04 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | -79,662,513.59 | -79,662,513.59 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 67,200,000.00 | 2,229,689.81 | 268,642,391.64 | 338,072,081.45 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 811,478,100.00 | 777,992,000.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 811,478,100.00 | 777,992,000.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 793,791,500.00 | 642,424,185.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 581,112,700.00 | 481,594,437.88 |
| 210101 | Үндсэн цалин | 337,695,000.00 | 291,131,100.88 |
| 210102 | Нэмэгдэл | 136,634,800.00 | 115,158,868.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 52,212,400.00 | 48,965,949.00 |
| 210104 | Урамшуулал | 54,570,500.00 | 26,338,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,119,000.00 | 57,720,186.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,703,400.00 | 40,207,973.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,863,800.00 | 4,313,481.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,969,500.00 | 3,233,796.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,916,400.00 | 2,352,400.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,665,900.00 | 7,612,535.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,043,700.00 | 34,034,159.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,483,700.00 | 1,236,865.62 |
| 210302 | Түлш, халаалт | 9,991,500.00 | 10,062,033.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,568,500.00 | 1,735,260.37 |
| 210304 | Байрны түрээс | 21,000,000.00 | 21,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,465,500.00 | 9,810,261.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,717,100.00 | 2,020,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,563,000.00 | 4,080,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,303,800.00 | 1,104,811.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 130,000.00 | 110,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,751,600.00 | 2,494,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,423,700.00 | 6,253,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,423,700.00 | 6,253,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 38,510,400.00 | 24,826,556.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 764,500.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 14,987,900.00 | 12,352,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,758,000.00 | 12,474,156.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,450,000.00 | 9,250,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,450,000.00 | 9,250,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 38,296,500.00 | 18,814,785.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,358,900.00 | 11,414,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 967,600.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 391,300.00 | 384,130.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 87,300.00 | 87,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 78,800.00 | 78,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,220,000.00 | 6,802,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 192,600.00 | 48,155.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 370,000.00 | 120,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 370,000.00 | 120,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,686,600.00 | 135,567,814.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,686,600.00 | 17,544,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 15,515,500.00 | 15,515,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,171,100.00 | 2,028,900.00 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | - | 118,023,414.48 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 118,023,414.48 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,500,000.00 | 4,387,200.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **131,049,064.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **131,049,064.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 126,474,040.57 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 47,771,043.00 |
| 210102 | Нэмэгдэл | 47,771,043.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,762,997.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,826,096.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 477,710.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 370,969.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 217,644.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 870,577.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 378,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 378,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 690,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 690,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 71,872,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 71,872,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,575,023.43 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,575,023.43** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 4,575,023.43 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 131,049,064.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 131,049,064.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,107,864.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 72,941,200.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 67,766.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 204.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 61,931.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5,630.1 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг асуудлын бүртгэлээр баримтжуулсан.

Зөрчлийн нийт дүн 67,766.9 мянган төгрөг бөгөөд бидний тогтоосон материаллаг байдлын түшингээс 47,847.6 мянган төгрөгөөр хэтэрсэн тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

5.1.1 Завсрын аудитаар хийсэн түүвэр тооллогын явцад хамруулсан эргэлтийн хөрөнгөнөөс 204.8 мянган төгрөгийн үнэ бүхий багаж арчилгааны цомог дутагдсан, байршил, тоо хэмжээ тодорхойгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл 72.4.3 “ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах; ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Орон нутгийн орлогод төвлөрүүлэх 204.8 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлэн биелэлтийг ирүүлнэ үү.

**3.2 Албан шаардлага**

5.2.1 Тусгай зориулалтын 54 нэр төрлийн 43,532.0 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудас, зарлагын баримтгүй, байгууллагын даргын тушаалаар данснаас хассан.

Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Тусгай зориулалтын 54 нэр төрлийн 43,531,979.05 /дөчин гурван сая таван зуун гучин нэгэн мянга есөн зуун далан есөн төгрөг таван мөнгө/ төгрөгийн бараа материалыг шаардах хуудас, зарлагын баримтгүй, байгууллагын даргын тушаалаар данснаас хассаныг зохих хууль журмын дагуу залруулах арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[2]т ирүүлэх;

5.2.2 Тус байгууллагын үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 29,642.8 мянган төгрөгийн анхны өртөг, 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр ашиглалтад орсон 28-08 ГСА фургон автомашин нь 2023 оны 9 дүгээр сард жолоочийн буруутай үйлдлээс болж эвдэрсэн ба хөрөнгө даатгалын хохирлын үнэлгээний Ашид Билгүүн ХХК-иас автомашины эвдрэл хохирлын үнэлгээг 18,400.0 мянган төгрөгөөр тогтоосон боловч хохирлыг нөхөн төлүүлээгүй, 2023 оноос хойш одоог хүртэл хэвийн байдалд оруулаагүй, оношилгоо хийгдээгүй

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.3.4 дэх “ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.3.5 дахь “Осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож,

[2] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах”,Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Хөдөлмөрийн тухай хуулийн 129 дугаар зүйл 129.1 дэх “Ажил үүргээ гүйцэтгэх үедээ аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн буруугаас эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, зөрчлийн, эрүүгийн хариуцлага ногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэж болно” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Даатгалын байгууллагаас тогтоосон хохирлыг 18,400,000.0 /арван найман сая дөрвөн зуун мянган / төгрөгийг нөхөн төлүүлэх, УАЗ фургон 28-08ГСА автомашиныг хэвийн байдалд оруулах арга хэмжээ авч ажиллах арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[3]т ирүүлэх;

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Байгууллагын автомашин жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж эвдрэл үүссэн 28-08ГСА фургон автомашиныг 2023 оноос хойш ашиглаагүй байхад тайлант онд 5,630.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож хөрөнгийг үнэгүйдүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 3.4 “ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх”; 3.5 “Осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах”, “Эвдэрсэн хөрөнгийг засаж ашиглалтад оруулах хүртэл хугацаанд элэгдлийг түр зогсоох нь санхүүгийн бодит байдлыг харуулах үндэслэл болдог” гэсэн зүйл заалтыг зөрчиж байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.4 дэх “ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгөөр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[3] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | | | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Түүвэр тооллогоор арчилгааны цомог дутсан. | 1 | 204.8 | 1 | 204.8 | | | | | | | | |
| 2 | Тусгай зориулалтын 54 нэр төрлийн 43.5 сая төгрөгийн бараа материалыг шаардах хуудас, зарлагын баримтгүй, байгууллагын даргын тушаалаар данснаас хассан. | 1 | 43,532.0 | | | 1 | 43,532.0 | | | | | | |
| 3 | 29.6 сая төгрөгийн 2017 онд үйлдвэрлэгдсэн 28-08 ГСА фургон автомашин нь 2023 онд жолоочийн буруутай үйлдлээс болж эвдэрсэн ба Ашид Билгүүн ХХК-аас автомашины эвдрэл хохирлын үнэлгээг 18.4 сая төгрөгөөр тогтоосон боловч хохирлыг нөхөн төлүүлээгүй, 2023 оноос хойш одоог хүртэл хэвийн байдалд оруулаагүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаагүй. | 1 | 18,400.0 | | | 1 | 18,400.0 | | | | | | |
| 4 | Байгууллагын автомашин жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж эвдрэл үүсэн 2023 оноос хойш ашиглаагүй байхад 5,630.1 мянган төгрөгийн элэгдэл тооцсон | 1 | 5,630.1 | | | | | 1 | 5,630.1 | | | | |
| | Дүн | 4 | 67,766.9 | 1 | 204.8 | 2 | 61,932.0 | 1 | 5,630.1 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй зөв уялдуулан тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 45 ширхэг 153.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | | | | 1 | |
| 2 | Урамшуулал, нэмэгдэлтэй холбоотой дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн батлуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр дангаар баталж, олон удаа өөрчилсөн нь шийдвэр гаргах ил тод байдал, хууль ёсны зарчимд нийцээгүй байна. | 1 | 1,748.0 | | | 1 | 1,748.0 |
| | Дүн | 2 | 1,748.0 | | | 2 | 1,748.0 |
| | Нийт дүн | 2 | 1,748.0 | | | 2 | 1,748.0 |